



# Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

ТӨРИЙН АУДИТ

Анх  
баталсан

56 дугаар  
тогтоол

2024.12.20

96 төсөл, арга хэмжээ  
20,159.2 сая.төг



Тодотгон  
баталсан

39 дүгээр  
тогтоол

2025.07.25

100 төсөл, арга хэмжээ  
15,066.0 сая.төг



ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



ЗАМЫН САН



БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН



ИХ ЗАСВАР

45 төсөл арга  
хэмжээ  
6,719.7  
сая.төг

3 төсөл  
арга хэмжээ  
1,653.6  
сая.төг

11 төсөл арга  
хэмжээ  
1,088.3  
сая.төг

20 төсөл  
арга хэмжээ  
5,604.4  
сая.төг



**ТӨСВИЙН ТОДОТГОЛООР ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХАССАН НЬ ӨМНӨХ ОНЫ ТӨСӨВЛӨЛТӨД ГАРСАН ЗӨРЧИЛ БУУРАХАД НӨЛӨӨЛСӨН.**



*Гол анхаарах асуудал*

*Захиалагч техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа ажлын тоо хэмжээг үнэн зөв, бодиттой тооцон, ажлын хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.*



**ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ**

**ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН Ч ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВРЫГ ХУГАЦААНДАА БОЛОВСРУУЛААГҮЙ, ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООГ ХУГАЦАА АЛДАЖ БАЙГУУЛСАН.**



*Сангийн яаманд гаргасан 5 гомдлын 2 гомдлыг үндэслэлтэй гэж хянасан тул худалдан авах ажиллагааг дахин зохион байгуулсан.*



**ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ**

Үндсэн хөрөнгийн бүртгэл



**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БҮРЭН ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОО ӨМНӨХ ОНООС ӨССӨН 4 ЗАРИМ ХӨРӨНГИЙГ БҮРТГЭЛД ТУСГААГҮЙ БАЙНА.**

*Аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 2,868.2 сая төгрөгийн 20 төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй.*

Орон нутгийн төсвийн санхүүжилт дутуу бүрдсэн, Сангийн яамнаас зарцуулалтын эрхийн хязгаарлалт хийсэнтэй холбоотой 5,071.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна.

*Гол анхаарах асуудал*

*Төсөвлөгдсөн хяналтын зардлыг гэрээ байгуулан олгож, хөрөнгө оруулалтын үр дүнд тавих шатны хяналтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.*



**Аймгийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн дундаж 83.5 хувь болж өмнөх оноос 20.0 хувиар өссөн.**






## ТАНИЛЦУУЛГА

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ





## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

## ТАНИЛЦУУЛГА



**Аймгийн Засаг дарга, Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч нарт өгсөн зөвлөмж**


Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зураг, төсөв, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг үнэн зөв боловсруулж, хүлээн авах комиссын актад хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг тодорхой тусгаж байх.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үнэлгээний хороог хугацаа алдалгүй байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бодитой хийж, ажлын даалгаврыг тогтоосон хугацаанд, иж бүрэн хүргүүлж байх.

Зураг, төсөвтэй ажлуудад зураг зохиогчийн хяналт хэрэгжүүлэх ажлын гэрээг заавал байгуулж, гэрээг дүгнэн, зураг өөрчлөгдөх бүрд өөрчлөлтийн зургийг баталгаажуулан баримтжуулж ажиллах.

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсвийн төслийг боловсруулахдаа Төсвийн тухай хуулийн зарчим, эрэмбийг мөрдөж ажиллах.

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд түншлэл санал болгосон тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээнд түншлэлийн үүргийг тодорхой тусгаж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих.





## ТАНИЛЦУУЛГА

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ



### Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт өгсөн зөвлөмж

✓ Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ажлын тайланг баримтжуулах, архивын нэгж үүсгэх.



### Орон нутгийн өмчийн газарт өгсөн зөвлөмж

✓ Холбогдох байгууллагын хөрөнгө бүртгүүлэх, хөрөнгө оруулалтаар бүрэн хэрэгжиж дууссан хөрөнгүүдийн баримт бичгийг бүрдүүлж орлого авах шийдвэрийг гаргуулахаар уламжилж, шийдвэрийг гаргуулан, холбогдох байгууллагын хөрөнгө бүртгүүлэх,



### Буянт сумын Засаг даргад өгсөн зөвлөмж

✓ Ачаа жигнэх пүү (Буянт сум) ажлыг зурагт зааснаас өөрчлөн гүйцэтгэснээс гарсан материалын зөрүүг Буянт сумын ЗДТГ-ын данс бүртгэлд тусгаж, зарцуулалтад хяналт хэрэгжүүлэх.





### Жаргалант сумын Засаг даргад өгсөн зөвлөмж

Шууд худалдан авалтаар бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдөн ажиллаж, шаардлага хангасан бага үнийн санал ирүүлсэн оролцогчоос худалдах авалтыг хийж байх.



Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Цамбагарав баг Олзвойн 3-р гудамж гадна зогсоол, тохижилтын ажлын даалгаварт тусгагдсан 511 м2 зүлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгүүлэх.

ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг орон нутгийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхгүй байх.

Хөрөнгө оруулалтаар бүрэн хэрэгжиж дууссан хөрөнгүүдийн бүртгэх шийдвэрийг гаргуулан, холбогдох байгууллагын хөрөнгөд бүртгүүлэх.

Хөрөнгө оруулалтын төлөвлөхдөө урсгал зардлын шинжтэй төсөл арга хэмжээг төлөвлөхгүй байх, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахгүй байх.

# Ховд аймаг дахь төрийн аудитын газар



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД  
БАЯРЛАЛАА



Эх сурвалж: Гүйцэтгэлийн аудитын тайлан

Аудитын тайлангийн дэлгэрэнгүйг: [WWW.AUDIT.MN](http://WWW.AUDIT.MN)-ээс